



МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК 2019 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

КОМПАНИЙН ТУХАЙ

Монголын цахилгаан холбоо ХК нь 1921 онд “Шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороо” нэрээр эмхлэгдэн байгуулагдсан, 98 жилийн түүхтэй, Монгол Улсын харилцаа холбооны салбарын ууган компани юм.

Компани нь 1992 онд “Монголын Харилцаа Холбоо” (МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО) компани, 1995 онд “Монголын Цахилгаан Холбоо” хувьцаат компани болон байгуулагдаж, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж байсан, Монголын Хөрөнгийн Биржэд бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани юм.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны 54.67 хувийг Монгол улсын Засгийн газар, 40.0 хувийг БНСУ-ын Кореа Телеком корпораци, 5.33 хувийг Монгол улсын болон гадаадын иргэд, хуулийн этгээд тус тус 1995 оноос 2018 оны хооронд эзэмшиж байсан.

Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Кореа телеком корпораци хооронд 2018 оны 4 сарын 19-ний өдөр байгуулсан гэрээний дагуу компанийн нийт хувьцааны 40 хувь буюу 10,348,111 ширхэг хувьцааг худалдах арилжаагаар Монгол Улсын Засгийн газар (МУЗГ) Монголын цахилгаан холбоо ХК-ийн хувьцааны хяналтын багцыг дангаараа худалдан авсан тул МУЗГ нь Компанийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн хувиас бусад хэсгийг худалдан авах тендерийн санал гаргаж, 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр нийт 7,572 ширхэг хувьцааг худалдан авсан.

Ийнхүү Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны 94.7 хувь буюу 24,499,287 ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн газар, 5.3 хувь буюу 1,370,989 ширхэг хувьцааг Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд тус тус эзэмшиж байна.

Монголын цахилгаан холбоо ХК нь эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд Улаанбаатар хот болон орон нутагт олон улс, дотоодын телефон яриа, интернэт, кабелийн телевиз болон мэдээллийн лавлах үйлчилгээг үзүүлж байна. Нийт 771 ажилтан, албан хаагчидтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Алсын хараа

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн өргөн сонголт бүхий үйлчилгээ үзүүлэгч, өрсөлдөх чадвараар салбартаа тэргүүлэгч компани байна..

Эрхэм зорилго

Харилцаа бүрийг холбоно.

Үнэт зүйлс

ХЭРЭГЛЭГЧИЙН ДЭЭДЛЭЛ:

- Бид хэрэглэгч бүрийг зочин мэт дээдэлнэ.
- Бидний бүх ажил ямагт хэрэглэгчийн төлөө байна.
- Бид хэрэглэгчээ танин мэдэж, хэрэгцээ шаардлагад нь өөриймсөг хандана.

ХАМТ ОЛОН:

- Бид бэрхшээл саадыг хамтдаа туулж, амжилт ялалтыг багаараа бүтээнэ.
- Бид өргөн мэдлэг, өөдрөг үзэл, бүтээлч хандлагыг эрхэмлэнэ.
- Бид зорилго, итгэл, урам зоригтойгоор ирээдүйг төлөвлөн бүтээнэ.

ХАРИУЦЛАГА:

- Бид ажилдаа эзэн байж, хариуцлагаа ухамсарладаг зарчимч байна.
- Бид хариуцлагатай байдлыг бусдын итгэлийг даах үндэс гэж үзнэ.
- Бид бүх нийтийн үйлчилгээний үүрэг хариуцлагаа эрхэмлэнэ.

БРЭНД НЭР:


- Бид “Монголын цахилгаан холбоо” хэмээх эрхэм алдрыг үргэлж дээдэлнэ.
- Бид компанийнхаа нэр төрийн илэрхийлэл гэдгээ үргэлж санана.
- Бид хэрэглэгч, харилцагч, хамтрагчиддаа компаниа үргэлж эерэгээр ойлгуулна.

Уриа үг

“Холбоо хөгжлийн төлөө хамтдаа”

Бүтэц зохион байгуулалт


Монголын цахилгаан холбоо ХК нь Монгол орон даяар үйлчилгээгээ хүргэн ажиллаж байгаа бөгөөд 2019 онд Улаанбаатар хотын 4 бүсийн холбооны газар, Багануур, Налайх дүүргийн холбооны газар, 21 аймгийн холбооны газар, төв оффисийн 6 газар, 15 албаны бүтэцтэйгээр үйл ажиллагааг явуулж ирлээ.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны **94.7** хувь буюу **24,499,287** ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн газар, **5.3** хувь буюу **1,370,989** ширхэг хувьцааг Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд тус тус эзэмшиж байна.



Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байдаг.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурал 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 11:00-14:00 цагийн хооронд компанийн төв байрны хурлын зааланд зохион байгуулагдлаа.

2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөр тасалбар болгон бүртгэсэн 25,870,276.0 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3,955 хувьцаа эзэмшигчдээс 24,048,640 ширхэг саналын эрх бүхий 22 хувьцаа эзэмшигч оролцож хурлын ирц 96.82 хувьтай байлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлууд

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
2. Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай
3. ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай
4. ТУЗ-ийн 2019 оны зардлын төсвийг батлах тухай
5. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн үндэслэлийг танилцуулах тухай

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэрүүд

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай асуудлыг 97.83 хувийн саналаар батлав.
2. Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын тайлан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 97.83 хувийн саналаар батлав.
3. ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай асуудлыг 97.83 хувийн саналаар батлав.
4. ТУЗ-ийн 2019 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 99.99 хувийн саналаар батлав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын эзгүйд компанийн бизнесийн үйл ажиллагааг удирдан явуулахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байдаг. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй, тэдгээрийн гуравны нэг (1/3) хараат бус гишүүн бөгөөд ердийн 6 гишүүн нь төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлдэг.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй бөгөөд ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

ТУЗ-ийн ДАРГА



Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга

ЕРДИЙН ГИШҮҮД



Г.ЭРДЭНЭБУЛГАН

ЗГ-ийн хэрэг эрхлэх газар, Хууль, эрхзүйн газар, Засгийн газрын референт



Ж.ЦОГТБАЯР

СЯ, СХЭУГ-ын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн дарга



Ч.ЦЭВЭГДОРЖ

Үндэсний Статистикийн Хороо, Тамгын газрын дарга



Д.АРИУНТУЯА

ХЗДХЯ, Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга



Т.ЛХАГВАСҮРЭН

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

ХАРААТ БУС ГИШҮҮД



Ж.ТАМИР

Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын дарга



Л.БОЛОРМАА

Төрийн банк, Хүний нөөцийн газрын захирал



Ц.НОРОВЖАМЦ

Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор

Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудитын хороо, Цалин, урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороодтой үйл ажиллагаагаа явуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан

2019 онд Төлөөлөн удирдах зөвлөлөөр 5 хурал, 10 асуудал хэлэлцэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 6 хурал, 21 асуудал хэлэлцэж, 16 тогтоол, 6 тэмдэглэл гарган хэрэгжилтийг ханган ажиллаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын хувьд Цалин, урамшууллын хороо 1 удаа, Аудитын хороо 2 удаа, Нэр дэвшүүлэх хороо нэг удаа тус тус хуралдаж санал, дүгнэлтээ боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулсан байна. Аудитын хороо 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцууллаа. Мөн 2018 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилаагүй үндэслэлээ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны зардлын төсвийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас 98.64 сая төгрөг байхаар баталсан бөгөөд гүйцэтгэлээр 85.12 сая төгрөг буюу 86 хувийн гүйцэтгэлтэй, 13.52 сая төгрөг хэмнэсэн байна.

Хүснэгт 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны зардлын гүйцэтгэл, төгрөгөөр.

| | Зардлын төрөл | Тоо | Нэгж зардал | Давтамж | Нийт дүн | Гүйцэтгэл | Хувь | Хэмнэлт |
|---|---|-----|-------------|---------|-------------------|-------------------|------------|-------------------|
| | 1. Цалин, холбоо, тээврийн зардал | | | | | | | |
| 1 | ТУЗ-ийн гишүүний цалин | 9 | 550,000 | 12 | 59,400,000 | 59,400,000 | 100% | - |
| 2 | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | 1 | 350,000 | 12 | 4,200,000 | 3,496,400 | 83% | 703,600 |
| 3 | ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбоо, тээврийн зардал | 1 | 150,000 | 12 | 1,800,000 | 200,000 | 11% | 1,600,000 |
| | Цалин, холбоо, тээврийн зардлын дүн | | | | 65,400,000 | 63,096,400 | 96% | 2,303,600 |
| | 2. Бичиг хэрэг, хурлын зардал | | | | | | | - |
| 1 | Бичиг хэрэг, хэвлэмэл материал, цай, кофены зардал | | 125,000 | 12 | 1,500,000 | 1,500,000 | 100% | - |
| 2 | Хурал зохион байгуулах байрны түрээс | | 200,000 | 6 | 1,200,000 | 200,000 | 17% | 1,000,000 |
| 3 | Бусад зардал | | 115,000 | 6 | 690,000 | 478,091 | 69% | 211,909 |
| | Бичиг хэрэг, хурлын зардлын дүн | | | | 3,390,000 | 2,178,091 | 64% | 1,211,909 |
| | 3. МГХХ-ны салбарын хурал, үзэгдэл, форумд оролцох, салбарын туршлага судлах, сургалтын зардал | | | | | | | - |
| 1 | Тээврийн зардал | | | | 18,000,000 | 9,756,600.00 | 54% | 8,243,400 |
| 2 | Зам хоног | | | | 1,600,000 | 3,914,531.00 | 245% | (2,314,531) |
| 3 | Зочид буудал | | | | 10,250,000 | 6,174,000.00 | 60% | 4,076,000 |
| | Төмийлтийн зардлын дүн | | | | 29,850,000 | 19,845,131 | 66% | 10,004,869 |
| | Нийт дүн | | | | 98,640,000 | 85,119,622 | 86% | 13,520,378 |

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Үндсэн үйлчилгээ

Монголын цахилгаан холбоо ХК нь Техник технологийн хөгжлийг даган хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцэх бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж, борлуулалтын орлогыг дэмжих хөнгөлөлт, урамшууллыг тогтмол хэрэгжүүлэн ажиллаа. Мөн борлуулалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор салбар нэгжүүдийг бүсчилсэн удирдлагад шилжүүлэн, тухай бүрийн онцлогт тохирсон борлуулалтын арга хэлбэрээр ажиллаж эхлээд байна.

1.1 Суурин утасны үйлчилгээ

Суурин утасны үйлчилгээг 2019 онд зах зээлд сурталчлан таниулах, үнэ цэнэ, ач холбогдлыг хүргэх чиглэлд онцлон хэрэгжүүлсэн ажлуудаас дурьдвал:

| | | |
|--|---|--|
| | | |
| <p>Өв уламжлалт Үнэт брэнд</p> <p>Харилцаа холбооны салбарын эхлэлийг тавьж, хөгжлийг түүчээлж үнэтэй хувь нэмэр оруулсан стратегийн ач холбогдол бүхий брэнд</p> | <p>Өсөн нэмэгдэх Үнэ цэнэ</p> <p>Орчин цагийн амьдралын хэв маягт нийцсэн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээ нь өрх гэрийн аюулгүй байдлыг хангах найдвартай туслагч</p> | <p>Өрх гэр, Өрөөний Чимэг</p> <p>Шинэлэг өнгө дизайн, хялбар нэмэлт функцүүд, үйл ажиллагааг хөнгөвчлөх боломжуудыг хамгийн бага өртөг зардлаар</p> |

Хувь /өрх/ хэрэглэгчид суурин утасны үйлчилгээг сонгосноор гэр бүл, үр хүүхэд, ахмад настантайгаа энгийн болон гэнэтийн яаралтай ямар ч үед хамгийн найдвартай холбогдох боломжтой юм. Мөн харилцаа холбооны бусад үйлчилгээтэй харьцуулахад хамгийн боломжит тарифаар үйлчилгээг санал болгож байна. Орчин үед хэрэглэгчид өнгө үзэмжтэй суурин утасны телефон аппарат ашиглах хандлага нэмэгдэж байгаа тул сонирхолтой шийдэл бүхий өргөн сонголттой телефон аппаратыг санал болгох болсноор суурин утасны хэрэглээ, өрөө, тасалгаандаа өнгө, чимэг нэмэх хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн юм.

Албан байгууллагын хэрэглэгчид хамгийн найдвартай суурин утасны үйлчилгээг түлхүү сонгох болсон бөгөөд тухайлбал 2019 онд Төрийн холбооны 89 байгууллагын 2,715 телефон цэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын 880 гаруй телефон цэгээр суурин утасны хэрэглэгчийн тоог нэмэгдүүлж ажиллалаа.

1.2 Олон улсын яриа

Дотоодод олон улсын ярианы шууд гарц бүхий 5 оператор компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Монголын цахилгаан холбоо ХК нь БНСУ-ын Korea Telecom, АНУ-ын AT&T, БНХАУ-ын “China Unicom”, ОХУ-ын Rostelecom, Япон улсын KDDI хамтран ажиллаж, дэлхийн 160 гаруй улстай 001 шууд гарц болон интернэт протоколд суурилсан ярианы VoIP 1636, 1637 гарцаар хэрэглэгчид олон улсын ярианы үйлчилгээг үзүүлж байна.

1.3 Интернэт үйлчилгээ

Өдрөөс өдөрт интернэтийн хэрэгцээ, өндөр хурдны шаардлага өсөн нэмэгдэж буй энэ цаг үе, боломжийг ашиглан 2019 онд интернэтийн үйлчилгээний зах зээлээ тэлэхийн тулд үйлчилгээний чанарт анхаарахаас гадна өрсөлдөхүйц тарифын шинэчлэлийг хийж, хурдыг нэмэгдүүлэн ажиллаа.

Хэрэглэгчид дан интернэт үйлчилгээг сонгохоос илүүтэй харилцаа холбооны бусад үйлчилгээтэй хосолмол байдлаар багцлан сонгох хандлага давамгайлах болсон тул суурин утасны үйлчилгээтэй хослуулсан багцын үйлчилгээг зах зээлд шинээр танилцуулаад байна.

Интернэт, суурин утасны хосолсон багц үйлчилгээнүүдээс дурьдвал:



Өрх болон байгууллагын хэрэглэгчид технологийн төрлөөс хамааруулан 30 хүртэлх Mbps хурдаар интернэт үйлчилгээг суурин утасны хэрэглээтэй хослуулан авах боломж бүрдсэн. Цаашид кабелийн телевизийн үйлчилгээ болон шинэ бизнес болох OTT үйлчилгээтэй хослуулан гуравласан багц үйлчилгээний сонголтыг хэрэглэгчдэд хүргэх зорилт тавин ажиллаж байна.

1.4 Кабелийн телевизийн үйлчилгээ

КаТВ-ийн хамрах хүрээг орон нутагт өргөжүүлэх чиглэлд анхааран Сүхбаатар, Баянхонгор,



Ховд, Дундговь аймгийн төв болон Баян-Өлгий аймгийн 4 сумдад шинээр үйлчилгээ нэвтрүүлсэн. National КаТВ-н телевизийн сувгийн тоог нэмэгдүүлж, чанарыг сайжруулахад анхаарч, компанийнхаа үйлчилгээг таниулж, сургах ргомо сувгийг шинээр байгуулж ажилласан. Мөн Хэрэглэгчдийн санал хүсэлтэд тулгуурлан OPT-1

сувгийг албан ёсны эрхтэйгээр дамжуулан, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөөлөл үзүүлсэн байна.

1.5 Үндэсний лавлах 1900-1109

Харилцаа холбооны брэнд лавлах үйлчилгээ 1900-1109-н лавлагаа, мэдээллийг өргөжүүлэн, сайжруулах, тасралтгүй шинэчлэхэд анхаарч ажиллаа. Мөн хэрэглэгчдийн санал, хүсэлт, гомдол, талархалыг хүлээн авч, дүн шинжилгээ хийж, эргэж хурдан шуурхай



холбогдох боломжийг бүрдүүлсэн “Voice of Customer” системийг анх удаа ашиглалтанд оруулж, Улаанбаатар, аймаг дүүргийн салбарын үйл ажиллагаанд нэвтрүүлэн, албан ёсны утсаар, албан бичгээр, биеэр, цахим хэлбэрээр хэрэглэгчийн дуу хоолойг бүх сувгуудаар хүлээн авч, хариу өгч ажиллаж эхлээд байна.

- www.telecommongolia.mn
- www.facebook.com/TelecomMongoliaCompany

1.6 Олон нийтийн үйл ажиллагаа

Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын томоохон үзэсгэлэн эсхпод оролцон, хийж бүтээж, үргэлжлүүлэн төлөвлөж буй үйл ажиллагааныхаа талаар хэрэглэгчид, харилцагчид, салбарын хамт олондоо танилцууллаа.



2019 оны 9 сарын 27-29 өдрүүдэд салбарын хамгийн өргөн цар хүрээтэй ICT EXPO зохион байгуулагдсан ба МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК үндэсний бахархалт суурин утасны үйлчилгээгээрээ хамрагдан, шилдэг 10 байгууллагын нэгээр шалгарсан онцлох үйл явдал болсон юм. Залуу өрх айл, шинээр байгуулагдаж буй албан байгууллага, хувийн бизнес эрхлэгчид суурин утасны үйлчилгээг түлхүү сонирхож, өдөр тутмын үйл ажиллагаанд ихээхэн ач холбогдолтой, давуу тал олонтойг онцолж байлаа. Эндээс үзвэл МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК нь суурин утасны зах зээлээ тэлэх, цаашид өргөтгөх бүрэн боломжтой бөгөөд 2020 онд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн чиглэлд анхаарал хандуулж, хэрэглэгчдэд шинэлэг,

өгөөжтэй байдлаар үйлчилгээг дахин хүргэхээр төлөвлөөд байна.

Сүхбаатар, Баянхонгор, Дундговь, Ховд аймгуудад болон Баян-Өлгий аймгийн 4 суманд кабелийн телевизийн үйлчилгээг шинээр оруулж, нээлтийн үйл ажиллагааг орон нутгийн хэрэглэгчиддээ хүртээмжтэй байдлаар зохион байгууллаа.



Сүхбаатар аймгийн шинэ үйлчилгээний нээлтийн үйл ажиллагаа нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос жил бүр зохион байгуулдаг бүсийн зөвлөгөөний үеэр таарсан нь онцлог үйл явдал болсон. Тус зөвлөгөөн нь “Харилцаа холбооны хөгжил” сэдвээр Говьсүмбэр, Дорнод, Дорноговь, Хэнтий, Сүхбаатар аймгуудыг хамруулсан өргөн бүрэлдэхүүнтэй явагдсан ба Монголын цахилгаан холбоо ХК орон нутгийн хэрэглэгчдэд харилцаа холбооны дэвшлийн үр шимээр дамжуулан хөгжлийг түгээж буйгаараа ач холбогдол өндөр байлаа.

2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтээс

Монголын цахилгаан холбоо ХК нь 2019 онд нийт 70 багц, 177 ажил төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Эдгээрээс гол томоохон ажлуудыг дурдвал:

- ✦ Үндсэн үйлчилгээний орлого, хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд Төрийн холбооны 26-тай дугаарын үйлчилгээг шилжүүлэн авч, 89 байгууллагын 2,715 телефон цэгийг холбосон. Иргэний нисэхийн ерөнхий газрын хэрэглэгчдийг 7128-xxxx-тай дугаарлалтад шилжүүлж, 800 гаруй телефон цэгээр суурин утасны хэрэглэгчийн тоог нэмэгдүүлсэн байна.
- ✦ Үндсэн үйлчилгээний өртгийг бууруулах зорилт тавин ажиллаж, интернэтийн бөөний урсгал болон хот хоорондын дамжуулах сүлжээний үйлчилгээ авч буй компаниудтай гэрээний нөхцлийг шинэчлэн ажилласны үр дүнд өртөг зардлыг 20%-35% хүртэл бууруулсан байна.
- ✦ "Шинэ зууны боловсрол төсөл"-ийн хүрээнд БСШУСЯ-тай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэн, цаашид хамтын ажиллагааг үргэлжлүүлэхээр болж, холбогдох гэрээнүүдийг сунгаж, 2.1 тэрбум төгрөгийн орлого оруулсан.
- ✦ Өндөр хурдны интернэт хэрэглэгч болон бодит хурдны интернэт хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэхээр 500 гаруй албан байгууллагуудад биечилсэн борлуулалт зохион байгуулж, хэрэглэгчийн тоог нэмэгдүүлсэн.
- ✦ Идэвхгүй төлөвт шилжиж буй хэрэглэгчдэд чиглэсэн урамшууллын хөтөлбөр төлөвлөж, хөтөлбөрийн дагуу суурин утас, интернэтийн нийт 480 хэрэглэгчийг хадгалж үлдэх зорилт тавин ажиллаж, зорилтод төлөвлөгөөг 37.9 хувиар давуулан хэрэгжүүлсэн.
- ✦ Шинэ биллингийн системийг нэвтрүүлснээр интернэт болон суурин утасны үйлчилгээг багцлах боломжтой болсон бөгөөд дан болон хосолсон багцын үйлчилгээний үнэ тарифыг шинээр батлаж, үйлчилгээнд нвэтрүүлсэн.
- ✦ Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт байрлах Өмнөд бүсийн холбооны газрын салбарын байрыг "Жишиг салбар төсөл"-ийн загварын дагуу тохижуулж, засварласан.
- ✦ Үндэсний лавлах 1900-1109 пэйж хуудсын идэвхжүүлэлтийг 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлүүлэн дуудлага хүлээн авах ажилтан ажиллуулж эхэлсэн.

3. Үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн шинэ технологи, хөгжүүлэлт



NGN
СУУРИН УТАСНЫ ШИНЭ ҮЕ

✦ Alcatel-ын E10 станцыг бүтээмж өндөртэй, ашиглалтын зардал багатай NGN станцаар сольж, шинэчилснээр, МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК нь уламжлалт суурин

утас/PSTN/-ны бүх станцуудыг шинэчлэх ажлыг дуусгаж, IP суурьтай дараа үеийн суурин телефон холбооны технологи руу бүрэн шилжлээ.

- ✚ NGN станцын ЭАТС45 байранд байрлах SOFTX3000 софтсвич нь нөөц станцын горимоор ажиллах боломжтой болсноор NGN үндсэн 2 станцтай болж, найдвартай ажиллагаа 100% хангагдлаа.



- ✚ БНСУ-ын U-ANGEL корпорацитай хамтран ажиллаж, хэрэглэгчийн төлбөр тооцооны нэгдсэн системийг шинэчлэн үйлчилгээнд нэвтрүүллээ. Шинэ төлбөр тооцооны систем нэвтрүүлж, мөн урьдчилсан

төлбөрт үйлчилгээний IN системийг шинэчилснээр интернэт, суурин утас хосолсон багцын үйлчилгээ, телефон ярианы тарифын багцууд, урамшуулал, тарифын сонголтууд гаргах боломжтой болсон.

- ✚ БНСУ-ын U-angel компанитай хамтын ажиллагааны хүрээнд хэрэглэгчийн дагалдах програм хангамжийн API gateway холболт болон бусад програм хангамжуудыг хөгжүүлэх (CaTV api, Broadband api, Bank api) ажил хийгдсэн.



- ✚ Дотоодын ТВ контент төвлөрүүлэх ажлын хүрээнд төвлөрсөн нэг эх үүсвэрээс шилэн кабелиар дамжуулан орон нутгийн NATIONAL КаТВ-үүдэд

контентийг хүргэх боломж бүрдүүлж, мөн КаТВ-ийн үйлчилгээ авах техникийн боломжгүй хэрэглэгчдэд интернетийн сувгаар OTT системд суурилсан телевизийн үйлчилгээ хүргэх контентын нэгдсэн баазтай болсон.

- ✚ Улаанбаатар хотын **өргөн нэвтрүүлгийн телевизүүдтэй шилэн кабелиар холбогдож**, дуу дүрсний өндөр чанартай, нягтаршил сайтай телевизийн сигналыг шууд хүлээн авдаг болсон. Ингэснээр Контент хостинг үйлчилгээ эрхлэх үндэс суурь тавигдаж, КаТВ-ийн үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн.



- ✚ Архангай /5км/, Баянхонгор /8км/ аймаг болон Налайх дүүрэг /12км/-т кабелийг шууд булах, сувагчлалд ашиглах, гол мөрний усанд суурилуулах, агаарын баганаар татах боломжтой, даацын

хамгаалалттай, халуу, хүйтний өндөх тэсвэртэй шинэ технологийн шилэн кабелийн туршилтыг Япон улсын KDDI болон OCC /шилэн кабель үйлдвэрлэгч/-тай хамтран гүйцэтгэж, нийт 25км шинэ технологийн шилэн кабелийг суурилуулан ашиглаж байна.

- ✚ Интернетийн үйлчилгээний чанарыг сайжруулж, Улаанбаатар хот, бүх аймгийн төвд **шилэн кабелийн FTTH, GPON сүлжээг өргөтгөн**, 1G сүлжээгээр нэгэн зэрэг олон



✚ Хэрэглэгчийг халамжлах буюу customer care үйл ажиллагааны хүрээнд хэрэглэгчийн хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээ, гомдол, санал хүсэлтийг илүү нарийвчлан мэдэх, мэдээлэл цуглуулах, мөн ирсэн хүсэлт саналыг холбогдох газар хэлтсүүдэд түргэн

шуурхай шийдүүлэх, хэрэглэгчид мэдээлэл хүргэхэд хэрэглэгчийн цаг завьг хэмнэх

а

ч



✚ Интернетийн сувгаар OTT системд суурилсан телевизийн үйлчилгээ үзүүлэх төслийг хэрэгжүүлэх зорилгоор дэлхийд технологиор тэргүүлэгч компаниудыг урьж, хамтран ажиллах санал тавьсан бөгөөд Голландын Mware Solutions компанитай хамтран ажиллахаар болж, тоног төхөөрөмжийн хүлээн авч, суурилуулан, ашиглалтанд шилжүүлсэн. **Системийн боломж HD,**

BD формат бүхий 80 TB суваг, VOD, H.264, H.265 формат, ухраах, нөхөн үзэх функцуудтай.

V

4. Онцлох ажлууд

С

1. **/VOICE OF CUSTOMER/** системийг үйлчилгээнд нэвтрүүллээ. ХХМТГ, ХХЗХ, Тагнуулын ерөнхий газрын МАБГ-тай хамтран ажиллаж, 26xxxx дугаарлалттай **Төрийн суурин телефон холбооны үйлчилгээ**, хэрэглэгчийг шилжүүлэн авах ажлыг зохион байгуулж, **суурин утасны 2,718 телефон** цэгээр хэрэглэгчийн тоогоо нэмэгдүүлсэн.
2. ХХЗХ-ноос 7128-xxxx дугаарлалтыг шинээр авч, Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод үйл ажиллагааны 28xxxx дугаарлалтыг өөрийн компанийн шинээр авсан дугаарлалт руу шилжүүлэх замаар **суурин утасны 883 телефон** цэгээр хэрэглэгчийн тоог нэмэгдүүлсэн..
3. Утасгүй өргөн зурвас /LTE/-ын интернэтийн үйлчилгээ эрхлэх 2,540-2,555 / 2,660-2,675 МГц радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл авснаар хөдөлгөөнт интернэтийн үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон.
4. МҮХАҮТ-ын гишүүнчлэлээ сэргээн, **Мэдээлэл холбооны операторуудын ассоциацийн** үндсэн гишүүнээр ажиллаж, компанийнхаа эрх ашгийг тухайн

төрийн бус байгууллагуудаар дамжуулан эрх бүхий байгууллагуудад уламжлан, идэвхтэй хамтран ажиллаж байна.

5. Интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр **FACEBOOK** компанитай хамтран ажиллахаар болж, судалгааны түвшинд хамтран ажиллаж байна. Энэхүү хамтын ажиллагааг бий болгосноор сум, орон нутагт интернэтийн үйлчилгээг өндөр нууцлал, хамгаалалттайгаар, бага зардлаар хүргэх боломжтой болно.
6. Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллагаас санаачлан хэрэгжүүлж буй “Монгол улсын хөдөө орон нутагт шинэ технологийн шилэн кабелийг элсэрхэг хөрс, хүйтэн бүсэд суурилуулан турших, хэрэглэгчдэд интернэт сүлжээ хүргэх” төслийн шалгуурыг хангаснаар Япон улсын KDDI сангаас 225.0 мянган ам.долларын санхүүжилт хийгдэж, шилэн кабелийн туршилтыг амжилттай хамтран хэрэгжүүллээ.
7. Борлуулалтын удирдлагыг сайжруулах чиглэлээр зөвлөх үйлчилгээ авч, маркетинг, борлуулалт, үйлчилгээний ажлын чиг үүргийг оновчтой зохион байгуулах, ажилтан бүр борлуулагч сэтгэлгээтэй ажиллах нөхцлийг бүрдүүлэх, борлуулалтын нэгжийн онцлогт тохирсон үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн.
8. Компанийн зүгээс хийж хэрэгжүүлж буй төсөл, ажлын талаар нийт ажиллагсдад мэдээлэл өгөх зорилгоор тайлангийн нэгдсэн хурлыг зохион байгуулж, ажилтан бүр нэг зорилготой, мэдээлэлтэй байх нөхцөлийг хангаж ажилласан.
9. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд газар, нэгжийн дотоодын ажлын зохион байгуулалтыг сайжруулах, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны түвшинг тогтоох, дүгнэлт хийх, зөвлөмж чиглэл өгөх, ажилтны ажлын хариуцлагыг дээшлүүлэх, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих компанит ажлыг өрнүүлж, хэрэгжүүлсэн.
10. Компанийн маркетингийн бодлогыг шинэ түвшинд гаргах зорилгоор “**BRAND BOOK**” -тэй болж, өөрийн компанийн хэвлэл, сурталчилгаанд хэрэглэх стандартуудыг тогтоосон.
11. Оросын Холбооны Улсын үндэсний OPT-1 телевизийн сувгийг албан ёсны эрхтэйгээр хүлээн авч, дамжуулах гэрээ байгуулж, КаТВ-ийн сувгийн тоогоо нэмсэн.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1. Санхүүгийн үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд

Үндсэн үйл ажиллагааны орлого 1.2 тэрбум төгрөгөөр тасарч, үндсэн үйл ажиллагааны өртөг, зардал 1.0 тэрбум төгрөгөөр хэмнэгдсэн бөгөөд EBITDA 3.0 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаа.

Үндсэн үйл ажиллагааны орлогын бууралтад суурин утасны суурь хураамжийн орлого 19 хувиар, суурин утасны гарах ярианы орлого 30 хувиар буурсан нь нөлөөлсөн.

Хүснэгт 2. Компанийн эдийн засгийн үзүүлэлтийн гүйцэтгэл, мянган төгрөгөөр, 2019 он

| Үзүүлэлт | 2018 оны гүйцэтгэл | 2019 оны төлөвлөгөө | 2019 оны гүйцэтгэл | Төлөвлөгөөний биелэлт, хувь |
|---|--------------------|---------------------|--------------------|-----------------------------|
| Нийт орлого: | 21,193,802 | 21,136,808 | 19,688,456 | 93% |
| -Үндсэн үйл ажиллагааны орлого | 19,823,192 | 20,124,204 | 18,890,400 | 94% |
| -Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 1,370,611 | 1,012,604 | 798,055 | 79% |
| Нийт зардал: | 17,913,871 | 17,811,723 | 16,561,580 | 92% |
| -Үндсэн үйл ажиллагааны зардал | 17,075,080 | 16,739,029 | 15,887,782 | 95% |
| -Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 838,791 | 1,072,694 | 673,797 | 63% |
| - үүнээс удирдлагын зардал | 2,534,791 | | 2,407,643 | - |
| Хүү, элэлгдэл, татварын өмнөх ашиг | 3,279,931 | 3,325,085 | 3,126,876 | 94% |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | 2,864,364 | 3,167,190 | 2,994,179 | 95% |
| Татварын өмнөх ашиг | 415,568 | 157,896 | 132,697 | 84% |
| Орлогын албан татвар | 99,549 | 109,000 | 70,680 | 65% |
| Цэвэр ашиг | 316,018 | 48,896 | 62,017 | 127% |
| Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | 0.98 | 0.99 | 0.99 | 100% |
| Нийт авлага | 2,591,962 | 4,535,158 | 2,166,452 | 78% |
| Нийт өглөг | 7,210,178 | 7,452,400 | 7,485,507 | 100% |
| Үндсэн ба нэмэгдэл цалин | 5,707,285 | 6,134,518 | 5,966,167 | 97% |
| НДШ | 747,972 | 828,160 | 804,143 | 97% |
| Нийт ажиллагсдын тоо /цалинтай/ | 740 | 770 | 770 | 95% |
| Хөрөнгө оруулалт | 4,842,264 | 5,108,400 | 3,943,325 | 77% |

Эх сурвалж: Монголын цахилгаан холбоо ХК, СТГ


Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд



Цэвэр ашиг
62.0
сая төгрөг



Төлсөн татвар
2.8
тэрбум төгрөг



Хөрөнгө оруулалт
3.9
тэрбум төгрөг



Нийт авлага
2.2
сая төгрөг



Нийт өглөг
7.5
сая төгрөг


2019 оны хөрөнгө оруулалтын зарцуулалт, хувиар



Хөрөнгө оруулалтын төслийн үр дүн,

- Үндсэн сүлжээний дотоод хурд УБ хотод 10 Гигабит/сек болсон.
- Улаанбаатар хот болон, бүх аймгийн төв, томоохон сумдад GPON сүлжээ нэвтрүүлснээр хэрэглэгчийн үйлчилгээний чанар, хурд нэмэгдсэн. Цаашид багцын үйлчилгээ, OTT үйлчилгээ, LTE технологид суурилсан өндөр хурдны өргөн зурвасын утасгүй интернэтийн үйлчилгээ нэвтрүүлэх өөрийн суурь сүлжээтэй болсон.
- Интернэтийн сүлжээгээр телевиз, контентийн үйлчилгээ үзүүлэх систем нэвтрүүлснээр телевизийн үйлчилгээний хүрээг тэлэх, хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн уян хатан телевизийн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдсэн.
- VOC төсөл хэрэгжсэн бөгөөд дотоод үйл ажиллагааны автоматжуулалт, хэрэглэгчийн гомдол барагдуулалтын удирдлагын систем ашиглалтанд орсон. Хэрэглэгчийн үйлчилгээний хурд, үр дүн, чанар сайжирсан.
- Ховд, Баянхонгор, Сүхбаатар, Дундговь аймгийн төв болон Баян-Өлгий аймгийн 4 суманд шинээр тоон кабелийн телевизийн үйлчилгээ нэвтрүүлснээр хэрэглэгчийн тоо 10 гаруй хувиар нэмэгдсэн.

ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР /сая.төг/



2. Хөрөнгийн зах зээлийн ханшийн статистик



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

1. Ур чадвар, сургалт, хөдөлмөр хамгаалал

- ✚ Аттестатчилал зохион байгуулах 2019 оны А/30 тоот журам шинэчлэгдэн батлагдсан. Журам, удирдамж, ажлын төлөвлөгөөг АДХГ-г хүргүүлж, мэдлэгийн шалгалтыг онлайнаар, ур чадварын шалгалтыг АДХГ-ын ажлын хэсгийн бүрэлдэхүүн авсан. Аттестатчиллын дүгнэлтийг УЗ-ийн 14 дүгээр хуралд танилцуулсан..
- ✚ Компанийн хэмжээнд хууль эрх зүй, дотоод журам, шинэ техник, технологи, дижитал маркетинг, хэрэглэгчээ сонсох, борлуулалтыг нэмэгдүүлэх, хамт олны уур амьсгалыг сайжруулах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр нийт 36 сургалт явуулж, давхардсан тоогоор 1,040 ажилтанг хамруулж, сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан.
- ✚ Зуны ажлын хувцас, гуталны үнийн судалгаа авч, гэрээ байгуулан, нийлүүлэгдсэн. Өвлийн ажлын хувцас, гутал худалдан авах гэрээ 291, 292 дугаарт гэрээ батлагдсан. Гэрээний дагуу 12-р сард нийлүүлсэн.
- ✚ Ажлын байрны хэвийн нөхцөлд ажиллаж байгаа 180 ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулсан.

2. Нийгмийн хариуцлагын тайлан

| Үзүүлэлт | 2018 он | 2019 он |
|---|-----------|-----------|
| Ажиллагсдын тоо | 794 | 770 |
| Хөдөлмөрийн зардал, мян.төг | 6,431,729 | 6,618,387 |
| Сургалт, хөгжилд зарцуулсан хөрөнгө, мян.төг | 20,528 | 63,307 |
| Хувьцаа эзэмшигчдийн тоо | 3,986 | 3,955 |
| Нийгэм рүү чиглэсэн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, мян.төг | 11,520 | 16,200 |
| Экологийн хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, мян.төг | - | - |
| Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлыг хангахад зарцуулсан хөрөнгө, мян.төг | 63,493 | 58,831 |
| Улсад төлж буй татвар, бусад шимтгэл, мян.төг * | 721,840 | 630,017 |
| Мэргэжлийн холбоод, нийгмийн сайн сайхны төлөөх байгууллагын гишүүний төлбөр, мян.төг | 14,496 | 45,578 |

НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ

Монголын цахилгаан холбоо ХК нь Компанийн тухай хуулийн дагуу болон компанийн дүрмийн дагуу компанийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахдаа дараах нөхцлийг биелүүлсний дараа хуваарилдаг. Үүнд:

1. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
2. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуульд заасан доод хэмжээнээс их байх;
3. Компани эргүүлэн авах үүрэгтэй хувьцааг бүрэн авсан байх;

Дараах шалтгаануудын улмаас 2018 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар Монголын цахилгаан холбоо ХК-ийн ТУЗ-өөс шийдвэрлэсэн. Үүнд:

1. Компанийн төлбөрийн болон хөрвөх чадварын харьцааны үзүүлэлтүүд буурах хандлагатай байгаа.
2. 2018 оны хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг хадгалах шаардлага тулгарсан.

Монголын цахилгаан Холбоо ХК

2019